



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 16 өдөр

Дугаар А/246

Мөрөн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.5.24, 66 дугаар зүйлийн 66.1, Орон нутгийн хамгаалалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 11.2, 11.3.3, 11.4.2, 11.8, 19 дүгээр зүйлийн 19.1.8, Батлан хамгаалахын сайдын 2020 оны А/133 дугаар тушаал, Монгол Улсын Засгийн газрын Батлан хамгаалах зарим чиг үүргийг Хөвсгөл аймагт төлөөлөн 2023 онд хэрэгжүүлэх гэрээний 4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөвсгөл аймгийн хэмжээнд зохион байгуулагдах орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн хээрийн дадлага сургууль зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Б.Мөнгөн-Эрдэнэ (Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга)

Гишүүдэд С.Батхуяг (Аймгийн Засаг даргын Тамгын газрын цэргийн штабын дарга, хурандаа)

Ү.Батбаяр (Цэргийн штабын тоо бүртгэл, нөхөн хангалтын ахлах офицер, дэд хурандаа)

Б.Мөрөндалай (Дайчилгааны офицер, хошууч)

М.Алтаншагай (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга)

Г.Базар (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга)

Б.Баасансүрэн (Хилийн цэргийн 0257 дугаар ангийн захирагч, хурандаа)

Ё.Пүрэвсүрэн (Хөвсгөл аймгийн Онцгой байдлын газрын дарга, хурандаа)

Г.Бумцэнд (Зэвсэгт хүчний 321 дүгээр салбарын захирагч, ахмад)

Захирамж-2023

6712010116

2.

А.Алтанцоож

(Хөвсгөл аймгийн Цагдаагийн газрын дарга,
хурандаа)

Г.Одсэр

(Баянзүрх сумын Засаг дарга)

Нарийн бичгийн дарга

Т.Анхбаяр

(Цэргийн штабын орон нутгийн хамгаалалтын бэлтгэл,
сургалтын офицер, хошууч)

2.Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн хээрийн дадлага сургуулийн төлөвлөлтийг холбогдох хууль дүрэм, удирдамж, зааврын дагуу боловсруулж нууц хадгалалт хамгаалалтын журмыг чанд баримтлан ажиллахыг ажлын хэсгийн гишүүн Цэргийн штабын дарга (С.Батхуяг)-д даалгасугай.

3.Сургалтад шаарагдах материал хэрэгсэл, сургагч багш нарыг томилгоожуулж хамтран ажиллахыг Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын дарга нарт үүрэг болгосугай.

4. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН